



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2020 оны 01 сарын 24 өдөр


Дугаар А/38

Улаанбаатар хот

Г Нийгмийн эрүүл мэндийн төвийн
дүрмийг батлах тухай Г


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1.6 дахь заалт, 21 дүгээр зүйлийг тус тус үндэслэн, Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны Байнгын хорооны "Эрүүл мэндийн салбарын бодлого, эрүүл мэндийн хууль, тогтоомжийг боловсронгуй болгох, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай" 2017 оны 22 дугаар тогтоолын 11 дэх заалт, Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.1.4-ийн 2 дахь заалтыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. "Нийгмийн эрүүл мэндийн төвийн дүрэм"-ийг хавсралтаар баталсугай.
2. Энэ тушаалын дагуу аймаг, дүүргийн Нийгмийн эрүүл мэндийн төвийн бүтэц, зохион байгуулалтыг зөвшилцэн, батлуулахаар Засаг даргад хүргүүлэхийг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга наарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтийг бодлого, зохицуулалтаар хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн газар /Т.Энхзаяа/, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв /Д.Нарантуяа/-д тус тус үүрэг болгосугай.



141200124

Эрүүл мэндийн сайдын 2020 оны 01 дүгээр сарын 11-ны өдрийн 1/38 дугаар тушаалтын хавсралт



Нийгмийн эрүүл мэндийн төвийн дүрэм

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийгмийн эрүүл мэндийн төв /цаашид "Төв" гэх/ нь харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд Эрүүл мэндийн тухай хуулийн 16.9-д заасан үйл ажиллагааг эрхлэх чиг үүрэг бүхий төрийн өмчит эрүүл мэндийн байгууллага мөн.

1.2. Төв нь үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүл мэндийн тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомж, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, тушаал, дүрэм, заавар, стандарт, удирдамжийг мөрдлөг болгон ажиллана.

1.3. Нийгмийн эрүүл мэндийн төв нь нийгмийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг дангаараа болон бусад эрүүл мэндийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, олон нийт, иргэдтэй хамтран явуулна.

1.4. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд орон нутгийн хэмжээнд нийгмийн эрүүл мэндийн зорилт болон тэргүүлэх чиглэлийг тодорхойлно.

1.5. Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1.5-д зааснаар хурлын шийдвэрийг үндэслэн Засаг дарга нь төвийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах бүрэн эрхийг эдлэнэ.

1.6. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нь тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн төвийн даргыг хууль тогтоомжид заасны дагуу томилж, чөлөөлөх бүрэн эрхтэй.

1.7. Төвийг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, тусгай мэргэжлийн төв болон төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг нь холбогдох чиг үүргийн хүрээнд мэргэжил арга зүйгээр хангана.

1.8. Төвийн бүтэц, зохион байгуулалт болон хүний нөөц, санхүүжилтийг харьялах нутаг дэвсгэрийн хүн амын тоо, төвлөрлийг харгалзан зохицуулна.

1.9. Төв нь тогтоосон журмаар хийгдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудсыг хэрэглэнэ. Өөрийн онцлогийг илэрхийлсэн бэлгэдэлтэй байна.

Хоёр. Төвийн зорилго, чиг үүрэг

2.1. Төвийн үндсэн зорилго нь харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, хянах, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

2.2. Төв нь зорилгын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.2.1. Хүн амыг өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, өвчнийг эрт илрүүлэх:

Энэ чиг үүргийн хүрээнд харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын дунд эрүүл мэндийн үзлэг, зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчин, түүний эрсдэлт хүчин зүйлийн сэргийлэлт, эрт илрүүлэлтийг зохион байгуулах, осол гэмтэл, хүчирхийллээс сэргийлэх, сэтгэц, зан үйлийн эрүүл мэндийг хамгаалах, архи, тамхи, мансууруулах бодисын хэрэглээг бууруулах, хүн амын хоол тэжээл, зохистой хооллолт, аминдэм, эрдэс бодисын дутлын сэргийлэлт, эмийн зохистой хэрэглээ, хүнсний аюулгүй байдлыг хангуулах, хүнсний хордлогот халдвар, БЗДХ/ДОХ/Сүрьеэ, вируст хепатитийн халдвар, гэдэсний болон амьсгалын замын халдварын урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрхэлнэ. Халдварт болон халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлсийн тархалт, тандалтын судалгаа, эрт сэрэмжлүүлэг, хариу арга хэмжээг энэ журмын 2.2.2-т заасан чиг үүргийг хариуцсан нэгжтэй, мэдээлэл сургалт сурталчилгааг энэ журмын 2.2.3 болон 2.2.4-т заасан чиг үүргийг хариуцсан нэгжтэй тус тус хамтран хэрэгжүүлнэ.

2.2.2. Эрүүл мэндэд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлийн тандах, судлах, хянах:

Энэ чиг үүргийн хүрээнд харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын дунд эрүүл мэндийн тандалт, судалгааг хийж, зонхилон тохиолдох халдварт (хүнсний хордлогот халдвар, БЗДХ/ДОХ/Сүрьеэ, вируст хепатитийн халдвар, гэдэсний болон амьсгалын замын халдвар) болон халдварт бус өвчин (осол гэмтэл, хүчирхийлэл, архи, тамхи, мансууруулах бодисын хэрэглээ)-ий тандалт, хяналт, дархлаажуулалт, тарилгат халдварт өвчний тандалт сэргийлэлт, халдварт өвчний эрт сэрэмжлүүлэг, хариу арга хэмжээг зохион байгуулах, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, онцгой нөхцлийн тайван цагийн бэлэн байдал, олныг хамарсан өвчлөлийн үеийн хариу арга хэмжээ, онцгой үеийн хариу арга хэмжээний зохицуулалт, лабораторийн шинжилгээг хийх, зохион байгуулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг эрхэлнэ.

Хүн амын эрүүл мэндийн тандалт судалгаа, лабораторийн шинжилгээний мэдээлэл, хяналт, өвчний эрт сэрэмжлүүлэг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, онцгой үеийн хариу арга хэмжээг зохион байгуулах, эдгээр чиглэлээр олон нийттэй харилцах, эрсдлийн үеийн мэдээлэл харилцаа, сургалт сурталчилгааг энэ журмын 2.2.4-т заасан чиг үүргийг хариуцсан нэгжтэй хамтран хэрэгжүүлнэ.

2.2.3. Эрүүл мэндийг дэмжих, хамгаалах:

Энэ чиг үүргийн хүрээнд харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын дунд тэдний эрүүл мэндийг дэмжих, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, тэдэнд эрүүл амьдралын хэв маягийг ойлгуулах, зөвлөх, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаанд

бусад салбар, аж ахуйн нэгж, олон нийтийн оролцоог ханган, хүүхэд, өсвөр үеийнхэн, оюутан, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настны эрүүл мэнд, нөхөн үржихүйн эрүүл мэнд, жендерийн асуудал, эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжин хамгаалах, эрүүл мэндийн зөвлөгөө өгөх нэгж, кабинетууд, нийтийн биеийн тамир, чийрэгжүүлэлт, идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих клуб, төвийн үйл ажиллагааг мэргэжил арга зүйгээр дэмжих, чиглүүлэх, орчны эрүүл мэнд, уур амьсгалын өөрчлөлт, агаарын бохирдлыг бууруулах, ахуйн шавж, мэрэгч устгал, ариутгал халдвартгийг, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, эмнэлгийн хатуу ба шингэн хог хаягдал, химиин хорт болон аюултай бодисоос сэргийлэх чиглэлээр арга хэмжээг хариуцан зохион байгуулах, зохицуулах үйл ажиллагааг эрхэлнэ.

Хүүхэд, өсвөр үе, ахмад настны эрүүл мэнд, хүн амын нөхөн үржихүйн эрүүл мэнд, орчны эрүүл мэнд, эрүүл ахуй, чийрэгжүүлэлт, идэвхтэй хөдөлгөөний хяналт, тандалт, судалгаа, лабораторийн чиглэлээр энэ журмын 2.2.2-т заасан чиг үүргийг хариуцсан нэгжтэй хамтран хэрэгжүүлнэ.

2.2.4. Эрүүл мэндийн боловсрол олгох:

Энэ чиг үүргийн хүрээнд харьялах нутаг дэвсгэрийн хүн амын дунд эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, хүн амын эрүүл мэндийн талаарх хэрэгцээ, дадал, хандлагыг судлан тандах, хүн ам, олон нийттэй харилцах үйл ажиллагаа, эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, эрүүл зан үйл, аж төрөх ёсыг хэвшүүлэхэд чиглэсэн тэмдэглэлт өдрүүдийн зохион байгуулах, бусад салбарыг эдгээр үйл ажиллагаанд татан оролцуулах, эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтны сургалтыг зохион байгуулах, мэдээлэл, нэвтрүүлэг, сурвалжилга бэлтгэх, нийтлэн түгээх, эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны танилцуулга бэлтгэх, хэвлэлийн эх бэлтгэл, фото зураг, мэдээ тайланг нийтлэх, хэвлүүлэх үйл ажиллагааг эрхэлнэ. Бусад чиг үүргийг хариуцсан нэгжтэй хамтран хэрэгжүүлнэ.

Гурав. Төвийн эрх, үүрэг

3.1. Төв нь Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан эрүүл мэндийн байгууллагын эрх, үүргээс гадна дараах эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ:

3.2. Төв нь нийгмийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын хувьд дараах эрх эдэлнэ:

3.2.1. Харьялах нутаг дэвсгэрийн хэмжээнд нийгмийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээтэй холбогдсон асуудлыг эрүүл мэндийн газар болон нутгийн захиргааны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

3.2.2. Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд нийгмийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний талаар аж ахуйн нэгж байгууллага, гэр бүл хувь хүнд мэргэжлийн зөвлөгөө, зааварчилга өгөх;

3.2.3. Төв нь үндсэн зорилго, чиг үүргийн хүрээнд төрийн болон төрийн бус байгууллага, иргэнд шаардлага тавих;

3.2.4.Өөрийн орны болон гадаад орны ижил төрлийн байгууллагатай хамтран ажиллах, хууль тогтоомжийн хүрээнд гэрээ хэлцэл хийх;

3.2.5.Орон нутгийн хэмжээнд нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, орон нутагт хэрэгжиж байгаа эрүүл мэндийн бусад төсөл, хөтөлбөрийг нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр арга зүйгээр хангах, хамтрах, хэрэгжилтийг хянах;

3.2.6.Хуулиар олгогдсон бусад эрх.

3.3.Төв нь нийгмийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын хувьд дараах үүрэг хүлээнэ:

3.3.1.Эрүүл мэндийн талаар гарсан хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, мэргэжлийн дээд шатны байгуулага, нутгийн захиргааны байгууллагын шийдвэр, улсын байцаагчийн шаардлагыг биелүүлэх;

3.3.2.Орон нутагт нийгмийн эрүүл мэндийн мэндийн тусlamж үйлчилгээний бодлого, чиглэлийг тогтоох, нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөр, дэд хөтөлбөрийг нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтийг зохион байгуулах, олон нийтэд сурталчлах;

3.3.3.Төвийн барилга байгууламж, оношилгоо, эмчилгээний багаж төхөөрөмж болон холбогдох бусад техник хэрэгсэл нь эрүүл ахуйн болон стандартын шаардлага хангасан, ажилтны хөдөлмөрийн онцлогт тохирсон, аюулгүй ажиллагааны нөхцөл, шаардлагыг хангасан байх;

3.3.4.Төв нь хувь хүн, гэр бүл, хамт олонд эрүүл мэндийн боловсрол олгох, хүн амын дунд эрүүл мэндийг дэмжих орчныг бүрдүүлэх талаар бусад байгууллагатай хамтран ажиллах;

3.3.5.Төв нь үйл ажиллагааныхаа тайлан мэдээг хугацаанд нь гаргаж өгөх, бусад байгууллага, иргэнийг эрүүл мэндийн асуудлаар өөрийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр хангах;

3.3.6.Төв нь үндсэн зорилго, чиг үүргийн хэрэгжилтийг хангах, эрчимжүүлэх хүрээнд эрүүл мэндийн үзлэгийн кабинет, мэргэжлийн зөвлөгөө өгөх нэгж, шинжилгээний лаборатори, студийг ажиллуулах, мэргэжил, арга зүйгээр хангах;

3.3.7.Ажилтан, мэргэжилтэнд мэдлэг мэргэжлээ дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, ажилтны нийгмийн баталгааг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

3.3.8.Нийгмийн эрүүл мэндийн сэдэвт арга хэмжээг харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах, тэмдэглэхэд орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, олон нийтийг татан оролцуулах;

3.3.9.Хууль, тогтоомж, тушаал шийдвэрээр заагдсан бусад үүрэг.

Дөрөв. Төвийн удирдах бүрэлдэхүүн түүний эрх, хэмжээ, хүний нөөц

4.1. Эрүүл мэндийн газар нь төвийн үйл ажиллагааг Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1.4-т заасны дагуу болон арга зүйн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, үр дүнг тооцон, хяналт тавин ажиллана.

4.2. Төв нь энэ дүрмийн 2.2-т заасан чиг үүргийг хэрэгжүүлэх болон захиргаа, санхүү удирдлагын бүтэц, зохион байгуулалттай байна.

4.3. Төв нь орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын нийгмийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

4.4. Төвд ажиллах үндсэн хүний нөөцийг анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллежийг төгссөн хүний их, бага эмч, нийгмийн эрүүл мэнд судлалч, эрүүл ахуйч, эрүүл мэндийн нийгмийн ажилтан, хөдөлмөрийн аюулгүй байдлын эрүүл ахуйч, шим тэжээл судлалч нараас бүрдүүлнэ.

Тав. Төвийн санхүүжилт

5.1. Нийгмийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний санхүүжилтийн эх үүсвэр нь улсын төсөв, орон нутгийн төсөв, эрүүл мэндийг дэмжих сан, орон нутгийг хөгжүүлэх сан, эрүүл мэндийн даатгалын сан болон аж ахуйн нэгж, байгууллагын хандив, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн зардал, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

5.3. Төвийн төсөв, санхүүжилттэй холбоотой үйл ажиллагаа нь Төсвийн тухай, Эрүүл мэндийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулагдана.

5.4. Үйл ажиллагааныхаа хүрээнд төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулна.

5.5. Төв нь урсгал санхүүжилт, хөрөнгө оруулалтын талаар тулгамдаж байгаа асуудлаар тухай бүр Эрүүл мэндийн газраар дамжуулан аймгийн Засаг даргын тамгын газарт хүсэлт гаргана

---оо---